



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/34

Улаанбаатар хот

Г

Хөрөнгө гаргах тухай

Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 19/24 дүгээр тогтоолоор батлагдсан “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийн 2.2.6, “Найрсаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай нийслэлийн Засаг даргын 2016 оны А/51 дүгээр захирамж, тус газрын дүрмийн 2.3, 3.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаадын иргэдийн санал гомдлыг хүлээн авах, мэдээлэл зөвлөгөө өгөх “Жуулчны мэдээллийн лавлах утас”-ны үйлчилгээг технологийн дэвшилд тулгуурлан сайжруулах ажлыг Колл Про ХХК-тай хууль, дүрэмд нийцүүлэн гэрээ байгуулж гүйцэтгүүлэхийг Лавлах утасны оператор /С.Баяржаргал/-д үүрэг болгосугай.

2. Гэрээт ажлын төлбөр болох 2,298,000 /Хоёр сая хоёр зуун ерэн найман мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Э.БАТТУЛГА